

“ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ”

ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

Нийслэл хотод оршин суугч иргэдийн тоо жилээс жилд өсөхийн зэрэгцээ Монгол улсын хүн амын 45 гаруй хувь нь нийслэлд оршин сууж байна. Хүн амын тооны өсөлтөөс хамаарч, хүнсний хэрэгцээ дагаж өсөн хүнсний зонхилох хэрэгцээ болох мах, сүүний үйлдвэрлэл нь нийслэлчүүдийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна.

Нийслэл нь 470.4 мянган га нутаг дэвсгэртэй Үүний 327.8 мянган га-г бэлчээрийн талбай эзэлж байгаа боловч, жилийн эцсийн мал тооллогын дүнгээс үзвэл бэлчээрийн даац 5,8 дахин хэтэрч нийтбэлчээрийн 15.3 хувь нь хүчтэй талхлагдсан байгаа нь сүүлийн 5 жилийн хүн ам, малын тоон өсөлтөөс улбаалан хотруу чиглэсэн их нүүдэл, эмх цэгцгүй газар олголтоос үүсэн байдал нь хотын ерөнхий төлөвлөгөө болон бэлчээрийн газарт сөргөөр нөлөөлж байна.

2013 статистикийн мэдээгээр нийслэлд тэмээ 120, адуу 30202, үхэр 64611, хонь 134616, ямаа 99540, гахай 18441, шувуу 323087 тоологдсон нь улсын нийт малын 0,7%, үхрийн 2,3% , гахайн 38,2%, шувууны 69,1%-ийг эзэлж байна. Мөн Улаанбаатар хот орчимд ойролцоогоор 163 фермийн аж ахуйд 5900 орчим сүүний үхэр байгаа бөгөөд голлох үүлдэр нь хар тарлан, алатау, симменталь үүлдрийн үхэр байна.

Хүн амын физиологийн нормыг үндэслэн нийслэлийн хүн амын мах, сүүний хэрэгцээг тооцож үзэхэд нийслэлчүүдэд жилд 70 сая литр сүү, 80 мянга орчим тонн мах шаардалагатай байгаа юм. Иймд Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх асуудлыг байгаль, экологи, газар, хот байгуулалт, хүн амын эрүүл мэндийн бодлогойтой нягт уялдуулж газар нутаг, бэлчээрийн даацад тохируулж малын тоог хязгаарлах, цаашид өндөр ашиг шимтэй, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх бодлогыг Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан, нийгэм, эдийн засаг, экологийн талаас нь иж бүрэн харгалзан үзэж, тодорхой хязгаарлалттайгаар бүсчилэн хөгжүүлж, хотын хүн амыг жилийн турш сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах, малын тэжээлийг одоогийхоос 3 дахин, сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн болон эрлийз үнээний тоог 3,5 дахин, сүү боловсруулах жижиг үйлдвэр, цехийн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэх шаардлага гарч байна.

Нийслэлд мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс бодлогын баримт бичиг гаргасан боловч түүний хэрэгжилт өнөөгийн шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаагаас тус салбарын цаашдын тогтвортой хөгжлийг хангахын тулд цогц арга хэмжээг оновчтой авч хэрэгжүүлж Нийслэлийн нутаг дэвсгэрт Монгол улсын үндсэн хууль, Хот байгуулалтын тухай хууль, Газрын тухай хууль, Монгол

Улсын Их хурлын тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага, Төрөөс мал аж ахуй эрхлэх талаар баримтлах бодлого, “Монгол мал” хөтөлбөрүүд нь Нийслэлийн “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх үндэслэл болж байна.

Энэхүү хөтөлбөр нь сүү, махны чиглэлийн үхэр ямаа, мах-ноосны хонь, гахай, шувууны аж ахуйг тэргүүн ээлжинд хөгжүүлэхэд чиглэгдэнэ.